



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ

2020 оны 1-р сар




МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 18,897 -2.1% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс, 9,476 -1.7%, МХБ-В индекс 7,845 -0.6% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.12.31	2020.01.31	Өөрчлөлт, %
DJIA (US)	28,462	28,256	-0.7%
S&P 500 (US)	3,230	3,225	-0.2%
Nikkei 225 (JP)	23,656	23,205	-1.9%
Hang Seng (HK)	28,319	26,312	-7.0%
DAX 30 (DE)	13,249	12,981	-2.0%
SMI (CH)	10,616	10,627	-0.1%

Валютын ханш

Валют	2019.12.31	2020.01.31	Өөрчлөлт, %
USD	2,734.33	2,751.57	0.6%
EUR	3,063.54	3,034.57	-0.9%
JPY	25.17	25.25	0.3%
RUB	44.06	43.61	-1.0%
CNY	392.39	396.67	1.0%
KRW	2.37	2.31	-2.5%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	4.2	-10%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,665.2	-0.9%
Бүртгэлтэй компани	198	198
Арилжаалагдсан хувьцаа	82	+7
Арилжаалагдсан өдөр	22	+0

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.12.31	2020.01.31	Өөрчлөлт, %
CHE	70.00	144.08	+205%
INV	2,198.00	2,656.00	+20%
BDL	7,655.00	8,855.00	+15.6%
MDR	338.44	389.85	+15.1%
SOR	1000.00	1,150.00	+15%

Зах зээлийн мэдээлэл

Монгол даатгал ХК-ийн арилжааг сэргээх

МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй "Хорго Хайрхан" ХК-ийг "Монгол даатгал" ХХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулж, оноосон нэрийг Монгол даатгал ХК болгон өөрчилж, бирж болон СЗХ-нд бүртгүүлснийг өмнөх сард мэдээлсэн. Тэгвэл тус компанийн үнэт цаасны арилжааг түр хугацаанд зогсоосон байсныг 2020 оны 1-р сарын 17-ны өдөр нээлээ.

Баян Алдар ХК-ийн арилжааг түр зогсоов

СЗХ-ны 2020 оны анхдугаар хуралдаанаар Баян алдар ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу тус компанийн хувьцааг 50 хуваах замаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн тул хувьцаа хуваахтай холбоотой үйл ажиллагаа ҮЦТХТ-д бүрэн хийгдэж дуусах хүртэлх хугацаанд тус компанийн үнэт цаасны арилжааг зогсоолоо.

Баянтээг ХК 2018 оны ногдол ашгаа тараав

Баянтээг ХК-ийн 2018 оны ногдол ашигт нэгж хувьцаанд 3,562.83 төгрөг таараасныг 2020 оны 1-р сар 15-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ҮЦТХТ дэх дансдад байршуулав.

Код	Компанийн нэр	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг/төг/	ХЗ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан ногдол ашиг/төг/
445	"Баянтээг" ХК (BTG)	2019-03-04	3,562.83	241	16,331	57,539,704.50

Дархан нэхий ХК 2019 оны ашгаасаа ногдол ашиг тараана, мөн хувьцаагаа хуваана

Дархан нэхий ХК нь 13 жилийн дараа буюу 2019 оны цэвэр ашгаасаа нэгж хувьцаанд 210 төгрөг буюу нийт 232.1 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэлээ. 2020 оны 9-р сарын 30-ны өдрөөс эхлэн компанийн байран дээрээ тарааж эхлэх бөгөөд ногдол ашгаа аваагүй үлдсэн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг 2020 оны төгсгөлд ҮЦТХТ-д байршуулна гэжээ.

Бүртгэх өдөр: 2020 оны 2-р сарын 25-ны өдөр

Тараах өдөр: 2020.09.30-2020.12.30 хооронд тараана

Түүнлэн, компанийн удирдлагаас хувьцааны арилжааны идэвхийг сайжруулах зорилгоор хувьцаагаа 1,000 хуваах шийдвэр гаргасан ба энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцүүлэхээр эзэхж байна.

ЛэндМН ББСБ ХК 2019 онд ногдол ашиг тараана

ЛэндМН ББСБ ХК нь 2019 оны ашгаасаа нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1.2 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараах шийдвэрийг гаргасан байна. Бүртгэлийн өдөр: 2020 оны 2-р сарын 25

Түмэн Шувуут ХК ногдол ашиг тараана

Түмэн шувуут ХК нь 2019 оны цэвэр ашгийнхаа 30 хувийг нийт хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн ба энэ нь нэгж хувьцаанд 4.8 орчим төгрөг болж буй юм. Бүртгэлийн өдөр тодорхойгүй байна.

Ард Кредит ББСБ ХК-ийн шинэ гүйцэтгэх захирал томилогдлоо

Ард кредит ББСБ ХК-ийн гүйцэтгэх захирлаар Гэрэлтийн Тэлмэнг ТУЗ-өөс томилсон байна. Тэлмэн нь ажлын туршлагын хувьд БНСУ LG, Монгол шуудан ХК зэрэг гадаад дотоодын компаниудад менежментийн болон гүйцэтгэх удирдлагын түвшинд ажиллаж байжээ.



Хамгийн их бууралттай

Хувьцаа	2019.12.31	2020.01.31	Өөрчлөлт, %
BUK	458.00	300.00	-34%
SIL	68.00	50.00	-26%
TVT	6,640.00	5,000.00	-24%
IBA	3,200.00	2,700.00	-15%
MSC	340.00	290.00	-14%

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн, сая төг	Эзлэх %
MNP	3,619,028	2,272.9	54.0%
AARD	528,961	886.1	21.0%
LEND	6,614,343	301.8	7.0%
INV	40,749	105.8	2.5%
APU	142,280	87.6	2.0%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2019.12.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
CHE	0.009	13.7	+145049.0%
INV	157.6	32.8	+20.8%
BDL	6.3	0.995	+15.6%
MDR	4.6	0.706	+15.1%
SOR	0.891	0.133	+15.0%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2019.12.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
BUK	60,248.7	20,784.5	-34.4%
SIL	3,150.7	834.0	-26.4%
TVT	2,194.2	541.9	-24.6%
IBA	1,270.6	198.5	-15.6%
MSC	10,200.0	1,500.0	-14.7%

Инвекор ББСБ ХК Төв Азийн зах зээлд нэвтэрнэ

Инвекор ББСБ нь Бүгд Найрамдах Киргиз Улсын Золотой Стандарт бичил санхүүгийн зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй компанид хөрөнгө оруулалт хийх замаар финтек болон хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн чиглэлээр явуулах дунд хугацааны стратеги төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр болжээ.

Монос хүнс ХК-ийн шинэ үйлдвэр ашиглалтад орлоо

Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр ашиглалтад оржээ. Нийт 1,700 гаруй м2 талбайд үйл ажиллагаа явуулах энэхүү үйлдвэр нь олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, хүнсний аюулгүй байдлын HACCP, үйлдвэрлэлийн зохистой дадал GMP зэрэг стандартуудыг хангах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн сүүлийн үеийн техник технологиудаар тоноглогдсон бүрэн автомат үйлдвэр аж.

ТОП-20 сагс шинэчлэгдлээ

МХБ-ийн Топ 20 сагс шинэчлэгдэж, өмнөх сагсад багтаж байсан 13 компани хэвээр үлдэж, GTL, ITLS, HBO, JTB, MMX, NEH, TCK хасагдаж, шинээр ADB, INV, MFC, TUM, SHG, UID, ERDN нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлэв.

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

ҮЦТХТ-д 1-р сард нийт 15,195 данс нээгдснээс 12,937 данс шинээр, 2,258 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 12,929 дотоодын иргэн, 2 гадаадын иргэн, 6 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгджээ.

Та өөрөө гар утаснаасаа шууд арилжаа хийхийг хүсвэл манай “Цахим данс” системд бүртгүүлээрэй.

“ЦАХИМ ДАНС” СИСТЕМ
 <https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment



Мөн гар утасны аппликэйшн татан авч, онлайн арилжаа хийж, дансаа хянах боломжтой.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 12-р сарын эцэст 20.8 их наяд төгрөг болж, өмнөх оны эцсээс 1.3 (6.8%) их наяд төгрөгөөр өсөхөд төгрөгийн хадгаламж 923.0 тэрбум төгрөгөөр, валютын хадгаламж 464.2 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 12-р сарын эцэст 897.4 тэрбум болж, өмнөх сараас 37.2 (4.3%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны эцсээс 71.2 (7.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жилийн эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018.12	2019.12*
Мөнгө M2	19,474.8	20,803.3
Бага мөнгө M1	4,031.0	3,916.0
Төгрөгийн харилцах	3,360.5	3,301.5
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	670.5	614.5
Бараг мөнгө	15,443.8	16,887.3
Төгрөгийн хадгаламж	10,156.3	11,079.3
Валютын хадгаламж	3,019.5	3,483.7
Валютын харилцах	2,268.0	2,324.3
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	968.6	897.4

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 12-р сарын эцэст 18.1 их наяд төгрөг болж, өмнөх оны эцсээс 870.4 (5.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 12-р сарын эцэст 824.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 144.5 (14.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны эцсээс 24.8 (2.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 12-р сарын эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 92.9 (4.8%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны эцсээс 40.6 (2.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 38. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 11.9 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 10.8 их наяд төгрөг болж нийт орлогын 90.5 хувийг эзэлж байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 11.4 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 627.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 12-р сард 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 271.7 (32.2%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 2.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 1.3 (2.5 дахин) их наяд төгрөгөөр өсчээ.

Зураг 41. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн оны эцсийн байдлаар, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.3 тэрбум ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 383.2 сая ам. доллараар буурчээ. Урсгал данс 1.4 тэрбум ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.4 тэрбум ам. доллар, анхдагч орлогын данс 1.3 тэрбум ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.


Зураг 48. Бараа болон үйлчилгээний худалдаа, сараар, сая америк доллараар



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2019 онд нийт 152 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.7 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум ам. доллар, импорт 6.1 тэрбум ам. долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 860.6 (6.7%) сая америк доллар, үүнээс экспорт 608.0 (8.7%) сая ам. доллараар, импорт 252.6 (8.0%) сая америк доллараар түс түс өсчээ.

Зураг 49. Экспорт, импорт, тэнцэл, жилээр, тэрбум америк доллароор




Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос эхлэн ашигтай гарч эхэлсэн бөгөөд 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр ашгийн хэмжээ 1.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 355.4 сая ам. доллараар (31.3%) өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2019 оны 12-р сард 20.5 сая ам. долларын ашигтай гарч, өмнөх сараас 12.9 сая ам. доллараар өссөн байна.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 12-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны эцсээс 5.2%-р өссөн байна.

Зураг 57. Улсын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 12-р сард өмнөх оны эцсээс 5.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.3 хувь (махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 16.0 хувь, ундааны дэд бүлгийн үнэ 4.4 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 7.1 хувь, орон сууц, үс, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь (цахилгаан, хийн Болон түлшний дэд бүлгийн үнэ 1.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2020 Стандарт инвестмент ҮЦК